

ТАНИЛЦУУЛГА

“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хуулийн төслийн тухай

Архив, албан хэргийн хөтлөлтийн тухай хуулийн төслийг архив, албан хэрэг хөтлөлт нь арга зүй, зохион байгуулалтын хувьд нэгдмэл төвлөрсөн байх, хадгалалт хамгаалалт аюулгүй, бүрэн бүтэн байх, ашиглалт хууль ёсны байх, албан хэрэг хөтлөлтийн болон архивын сан хөмрөгийн бүрдүүлэлт тогтмол үнэн зөв, бүрэн байх үндэслэлээр боловсрууллаа.

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг энэхүү хуулийн төсөлд анх удаа хуулийн хэм хэмжээгээр зохицуулав. Албан хэрэг хөтлөх журам Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хамаарах тул албан хэрэг хөтлөлтийг хуульчлан журамласнаар энэхүү үйл ажиллагаа боловсронгуй болж, баримт бичигтэй харьцах албан хаагчдын хариуцлага сайжирна.

Хуулийн төсөлд Монгол Улсын архивын тогтолцоо, үндэсний архивын сан хөмрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэгч болох байгууллагын архивын талаар заалтууд орууллаа. Одоо даган мөрдөж байгаа Архивын тухай хуульд байгууллагын архивын үйл ажиллагааг тусгаагүйн улмаас анхан шатанд архивын баримт бүрдүүлэх, төрийн архивын баримтыг нөхөн бүрдүүлэх ажиллагаа хангалтгүй явж ирсэн байна.

Архивын төрлийг байгууллагын, төрийн архив гэж тодорхойлов. Өмчийн хэлбэрээс үл хамааран байгууллага бүр архивтай байхаар, үндэсний төв архив, төрөлжсөн архив, аймаг, нийслэлийн архив, тусгай архив нь төрийн архивын эрх хэмжээтэй ажиллахаар заалаа. Ийнхүү төрөлжүүлж ангилснаар архивын баримт бүрдүүлэх, шилжүүлэх, хадгалах үйл ажиллагаа улсын хэмжээнд тодорхой, найдвартай тогтолцоогоор явагдах юм.

Монгол улсын түүх, соёлд холбогдох, шинжлэх ухаан, танин мэдэхүйн онцгой ач холбогдолтой архивын баримт болох үнэт, хосгүй үнэт архивын баримтыг Үндэсний төв архивт төвлөрүүлэн хадгалах зохицуулалт тусгав.

Архив албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхой тусгав. Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллах Сургалт, судалгааны төвийн бүтэц, үйл ажиллагааны талаар тусгалаа.

Практикт гарч байгаа хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэж, архивын баримт түр хадгалах үйлчилгээний тухай шинээр зүйл заалт нэмлээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн улсын хяналтыг босоо тогтолцоонд оруулж, архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн хяналтын албаны дүрмийг Засгийн газар баталж байсныг өөрчилж, хяналтын алба, улсын байцаагчтай холбоотой зохицуулалтыг хуульд тусгаж, хуулиас гадна дүрмээр зохицуулах явдлыг халлаа.

Архивын ерөнхий газрын дэргэд баримт нягтлан шалгах орон тооны бус комисс ажилладаг байсныг өөрчилж, тухайн комиссын чиг үүргийг Архивын ерөнхий газрын гүйцэтгэх үндсэн чиг үүрэгт оруулж тусгасан ба ингэснээр архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах тус газрын эрх, үүрэг бүрэн хангагдах юм.

Харин байгууллагын болон төрийн архивын дэргэд баримт нягтлан шалгах орон тооны бус комисс байхаар зааж, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг тусгав.

Цахим албан хэрэг хөтлөлт, цахим архивын асуудлыг зохицуулсан хэм хэмжээг шинэчлэв. Практикт олон төрлийн журам, дүрэм, стандартаар зохицуулж буй асуудлыг эмх цэгцтэй болгох, цаасан суурьтай болон цахим архивын баримтын хүчин төгөлдөр байдлыг хангах талаар зохицуулалт орууллаа.

Төрийн архивын баримтыг түүх, соёл, улс төр, эдийн засаг, эрдэм шинжилгээ, судалгаа, боловсрол гэгээрийн арга хэмжээнд ашиглуулах түүнчлэн иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн архиваас тодорхой бүлгийн хүмүүст үнэгүй үйлчилгээ үзүүлэхээр тусгалаа.

2015 онд явагдсан байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн дүнгээс үзэхэд төрийн 1716 байгууллагын 1184 нь албан хэрэг хөтлөлтийн, 1471 нь архивын орон тооны ажилтангүй байна. 462 байгууллага нь архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг нэг ажилтанд хавсруулан гүйцэтгүүлж, 298 байгууллага нь багш, эмч, нярав, нябо гэх мэт үндсэн ажилтнуудад архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг хамтад нь хавсруулсан байна. Ихэнх төрийн архивууд, ялангуяа аймгийн архивууд нь 2-3 орон тоотой ажиллаж байгаа нь төрийн архивын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог хангахгүй байна.

1995 оны байдлаар 200 гаруй байгууллагын баримтаар нөхөн бүрдүүлэлт хийдэг байсан бол 2015 оны байдлаар 900 гаруй болж, ажлын ачаалал 4 дахин нэмэгдсэн. Тэгтэл 1995 онтой харьцуулахад орон тоо 15 хувиар багассан байна.

Иймд хуулийн төсөлд төрийн архивт байвал зохих ажилтныг мэргэжлээр нь тухайлан зааж, архивын салбарын ажилтны ёс зүйн шаардлага ба мэргэшлийн зэрэглэлийг тодорхойлж, ажилтны хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар зохицуулалт орууллаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төсөл нь найман бүлэг, 52 зүйлтэй.

Хуулийн төслийг боловсруулахдаа ОХУ, АНУ, Япон, БНХАУ, Эстони, ХБНГУ зэрэг архив, албан хэрэг хөтлөлтийн талаар олон арван жилийн түүх, соёлтой улсуудын хууль тогтоомж, олон улсын стандартыг харьцуулан судлахын зэрэгцээ

өөрийн орны архив, бичиг соёлын түүхэн уламжлал, архивын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд гарч буй ололт, амжилт, туршлагад тулгуурласан болно.

---ooOoo---